



## ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/203

Хэрлэн сум

### 2024 оны элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх урьдчилан сорилгын шалгалтад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.11, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хоёрдугаар хуралдааны 2020 оны 06 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хорин гуравдугаар хуралдааны 2023 оны №02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх, төгсөх ангийн сурагчдын сурлагын үр дүнг тооцох зорилгоор аймгийн 12 сургуулийн 712 шалгуулагчаас урьдчилан сорилгын 2 удаагийн шалгалт авахад зориулж 5,000,000 (таван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх "Сургууль, цэцэрлэгүүдийн сургалтын чанарыг ахиулж, үр дүнг тооцно" арга хэмжээний зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ